



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/421

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлэг тэмдэг болох хөх бухын чихмэл тоглоомыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэх гүйцэтгэгчээр “Декмон” ХХК-ийг сонгож, 18,000,000 (арван найман сая) төгрөгийг хавсралтаар баталж, гэрээ байгуулан, хяналт тавьж, хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

2. “Алтаргана 2024” наадамд зориулсан хөх бухын чихмэлийг ажлын даалгаврын дагуу чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн, гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөхийг “Декмон” ХХК-ийн захирал (Б.Бат-Эрдэнэ) -д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



06 дугаар сарын 07 ны/ний өдрийн 07 дугаар захирамжийн хавсралт



“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлгэдэл хөх бухын чихмэл худалдан авах зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
2	Хөх бухын чихмэл	1000 ш	18,000	18,000,000
Нийт үнэ				18,000,000